



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Гадаадын иргэнд тавих зарим хяналтыг
сайжруулах тухай

Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын виз олгох журам” –ын 7.2, Засгийн газрын 2018 оны 146 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам”-ын 12.7-д заасан хугацаанд тавих, хоёрдмол харьяалал үүсгэсэн иргэдийн мэдээллийн сан үүсгэх зорилгоор төв, орон нутаг болон хилийн боомтод ажиллаж буй нийт албан хаагч нарт ДААЛГАХ нь:

1. Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа болон төвөөс оршин суух зөвшөөрөл авах, бүртгүүлэх үед Монгол Улсын харьяат иргэд хоёрдмол харьяалал үүсгэсэн нөхцөл илэрвэл Газрын даргын 2009 оны 275 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан хоёрдмол харьяалал үүсгэсэн иргэний өргөдөл-анкетыг үнэн зөв бөглүүлж, гадаад улсын болон Монгол Улсын баримт бичгийг хуулбарлан авч Виз, зөвшөөрөл, харьяатын газарт тухай бүр ирүүлж ажиллах;

2. төвөөс олгосон “J” жуулчин ангиллаас бусад визийн зөвшөөрөлгүйгээр хилийн боомтод ирсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнд виз олгохгүй байх;

3. хасалтын хугацаанд тус улсаас гараагүй гадаадын иргэдийн мэдээллийг 14 хоног тутамд харьяалах нэгжийн гадаадын иргэний хяналтын улсын ахлах байцаагчдад мэдэгдэх;

4. Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж явц, үр дүнг улирал тутам танилцуулахыг Виз, зөвшөөрөл, харьяатын газар /Ч.Нармандах/-т даалгасугай.

ДАРГА

Д.МӨРӨН



000000009